



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАН

2024 ОНЫ 08 ДУГААР САРЫН 26-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 08 дугаар сарын 26-ны өдөр, Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-6

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы 8 дугаар сарын
26-ны өдөр /Даваа гараг/-ийн нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 99 гишүүн хүрэлцэн ирж, 78.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 46 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Алдаржавхлан, Х.Баттулга, П.Батчимэг, С.Бямбацогт, А.Ганбаатар, Д.Ганмаа, Д.Жаргалсайхан, Б.Пүрэвдорж, Б.Чойжилсүрэн;

Чөлөөтэй: Л.Оюун-Эрдэнэ, Ч.Ундрэм;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Баярмаа, Х.Ганхуяг, А.Ундраа;

Тасалсан: Н.Алтанхуяг, Т.Аубакир, Э.Бат-Амгалан, Д.Батлут, Б.Батцэцэг, Г.Ганбаатар, Л.Гантөмөр, П.Мөнхтулга, Н.Номтойбаяр, Дам.Цогтбаатар, Ж.Энхбаяр;

Хоцорсон: Б.Түвшин-01 минут.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Л.Мөнхбаатар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлэг, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгээс Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс авсан завсарлагын хугацаа дууссаныг мэдэгдэж, бүлгийн байр суурийг илэрхийлээд үргэлжлүүлэн хэлэлцэх шаардлагатай байгаа тул завсарлагын хугацааг сунгуулах саналтай байгаа тухай мэдэгдэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д Энэ хуульд өөрөөр заагаагүй бол нам, эвслийн бүлэг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30.1.5-д заасны дагуу завсарлага авах эрхтэй. Завсарлага авах хугацаа ажлын 5-аас илүүгүй өдөр байх бөгөөд шаардлагатай бол нам, эвслийн бүлгийн хүсэлтээр хуралдаан даргалагч завсарлагын хугацааг нэг удаа ажлын 3-аас илүүгүй өдрөөр сунгаж болно гэж заасны дагуу завсарлагын хугацааг 1 өдрөөр сунгав. /11:52/

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга

Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 08 минут үргэлжилж, 126 гишүүнээс 101 гишүүн хүрэлцэн ирж, 80.2 хувийн ирцтэйгээр 11 цаг 54 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ПРОТОКОЛЫН АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 08 дугаар сарын 26-ны өдөр,
Даваа гараг Төрийн ордон “Их
хуралдай” танхим 12 цаг 42 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгаж, мэндчилж. Ирвэл зохих 119 гишүүнээс 99 гишүүн хуралдаа ирсэн байна. Хурлын ирц 78.6 өнөөдрийн нэгдсэн хуралдаан эхэлснийг мэдэгдье ээ.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг уншиж танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанаар дараах 3 асуудлыг хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Хоёрдугаарт, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн хийнэ.

Гуравдугаарт, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна аа.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэгдүгээрт, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд үргэлжлүүлэн хэлэлцэж эхэлнэ.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан 2024 оны 8 дугаар сарын 23-ны өдөр Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн дарга Лхагвын Мөнхбаатар 2024 оны 8 дугаар сарын 26-ны Даваа гаргийн 10 цаг хүртэл завсарлага авсан байгаа. Завсарлагын хугацаа дууссан байна.

Завсарлагын хугацаа дууссантай холбогдуулан уг хэлэх асуудал байна. Намын бүлгүүд өнөөдөр бас өглөөнөөс эхлэн хуралдаж дөнгөж сая дууссан байгаа. Тийм учраас бас өнөөдрийн чуулганы хуралдаан оройтож эхэлж байгаа.

Ингээд завсарлага авсан байсан МАН-ын бүлгийн дарга Лхагвын Мөнхбаатарт уг өгье өө.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын эрхэм гишүүдийн амрыг эрье. Өнгөрсөн баасан гаргийн чуулганы хуралдаанаар хэлэлцэж байсан асуудлуудаас 3 хуулийн төслийн хэлэлцүүлгээс МАН-ын бүлэг завсарлага авсан. МАН-ын бүлэг хуралдаж байгаа эдгээр 3 асуудлуудаа хэлэлцлээ.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бас бүлгийн хуралдаан дээр бас хэлэлцлээ. Ингэхдээ уг хууль бол төсвийн төлөвлөлт, төсвийн хяналт, хариуцлага, эдийн засгийн аюулгүй байдал гээд олон асуудлуудыг бас хөндсөн. Ийм томоохон

бас ийм өөрчлөлтүүд хийгдэхээр орж ирсэн. Энэ дээр бүлгийн гишүүд бас байр сууриа нэгтгэх нэгдсэн ойлголтод хүрэх зайлиггүй шаардлага байгаа. Энэ агуулгаар нь уг асуудлыг завсарлагаа сунган уг асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн.

Хоёр дахь асуудал байна. Хоёр дахь асуудал бол энэ уг хуультай дагалдуулан орж ирсэн Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл байгаа юм.

Энэ хуулиар бол төсвийг өргөн барихтай холбоотой асуудлыг зохицуулсан ийм харилцааг оруулж ирсэн. Улсын төсвийг бол тухайн жилийнхээ 9 сарын 1-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлдэг ийм хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаа. Уг хуулийн он сарыг бол 10 сарын 1-нд өргөн барихаар өргөн мэдүүлсэн байна. Үүнийг бас Улсын Их Хурлын бүлгийн гишүүд хуралдаад хуучнаараа буюу 9 сарын нэгэндээ өргөн мэдүүлж байх нь зүйтэй юм аа. Яагаад гэвэл өргөн мэдүүлснээс хойш аудитын дүгнэлтийг бас гаргуулж авдаг. Улсын Их Хурлын гишүүд танилцана. Мөн тойрогтоо болон олон нийтэд хэлэлцүүлэг өрнүүлэх энэ цаг хугацааг нь олгох нь зүйтэй гэж бас үзэж байгаа юм. Тэгэхгүй бол 10 сарын 1-нд өргөн барьсан тохиолдолд аудитын дүгнэлтийн дараа бусад хэлэлцүүлгүүд өрнөхгүйгээр 11 сарын 15 гээд цаг хугацаанд ихээхэн шахагдан баталдаг энэ асуудлыг бас бид эргэж авч үзэх нь зүйтэй. Хуучин буюу хүчин төгөлдөр үргэлжилж байгаа энэ хуулиараа 9 сарын нэгэндээ өргөн мэдүүлээд авах нь зүйтэй гэж үзэж уг хуулийн төслийг хууль санаачлахад буцаах нь зүйтэй гэж үзлээ.

Гурав дахь асуудал байгаа юм. Энэ бол төсвийн тодотголтой хамт дагалдуулан орж ирсэн хуулиуд байгаа. Энэ дотор Төрийн болон орон нутгийн

өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Тендерийн хууль гэсэн үг. Энэ хууль дээр бас хуульд нийцээгүй зүйлүүд бас орж ирсэн байна. Тэр дотроо бас улсын төсөв батлах эрх, онцгой бүрэн эрх Улсын Их Хуралд бий. Энэ бүрэн эрхэд бас халдсан байж болзошгүй ийм зүйл заалтууд байгаа учраас энэ асуудлыг эргэж харах нь зүйтэй гэж үзэж байгаа юм. Тухайлах юм бол энэ чадавхад суурилсан хэлэлцээний аргаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад багтсан төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг санхүүжилтийн эх үүсвэр батлагдахаас өмнө эхлүүлж болно гэж ингээд тусгасан байна. Энэ бол улсын төсөв батлах онцгой бүрэн эрхэд бас халдсан зүйл байж болзошгүй байна.

Нөгөөтээгүүр хэрвээ ингээд явах юм бол энэ тендер шалгаруулалт нь эхэлчих юм бол түүний өртөг, санхүүжилт, арга хэмжээний санхүүжилтийг бол Улсын Их Хурал батлахаас өөр аргагүйд хүрнэ гэсэн үг. Энэ мэтчилэн түүнээс гадна энэ дээр бас хууль хууль зүйн хувьд нэр томъёог жигдлэх, зөвлөх үйлчилгээ болон төлбөр гардуулах нөхцөл гэсэн нэр томъёонуудыг бол зайлиггүй нэгдүгээрт тодорхой болгох ийм бас шаардлагууд байна. Нөгөөтээгүүр ер нь нэг тодорхой төсөлд зориулан энэ тендерийн хуулийг өөрчлөх биш уг хуулийг томоохон төсөл хөтөлбөрүүдийг явуулах түргэн шуурхай явуулах энэ боломжийг нь бүрдүүлэх асуудлаа хуулийн хүрээнд хуульд нийцүүлж гэхдээ энийгээ олон улсын болоод бусад ер нь сонгон шалгаруулалтаар явах механизмуудыг судлаад энэ зүйлүүдээ оруулж ирье.

Нөгөөтээгүүр ер нь энэ тендерүүдтэй холбоотой энэ хууль тогтоомжуудыг бүрэн шинэчилсэн найруулга хийх нь зүйтэй байна аа. Яагаад гэвэл олон нийтийн оролцоотой

ил тод, нээлттэй бүр хиймэл оюун ухаанд буюу хүнээс үл хамаарсан байдлаас ч энийг зохион байгуулах энэ шаардлагуудад нийцүүлэн шинэчлэн найруулах нь зүйтэй гэж үзэж хууль санаачлагчдадаа буцаах нь зүйтэй гэсэн ийм шийдлийг бас манай бүлэг дээр ярилаа.

Энэ хуультай хамт өргөн мэдүүлсэн бас нэг зүйл байгаа юм. Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулахаар өргөн мэдүүлж орж ирсэн. Энэ хууль бол бас тодорхой хууль тогтоомжуудыг бас зөрчиж байна гэж үзэж байгаа юм. 2023 онд энэ хууль Концессын тухай хууль хүчингүй болсон. Гэхдээ энд концессын тухай хуулийн дагуу төсөл сонгон шалгаруулалт зарласан тохиолдолд шалгарсан этгээдтэй концессын гэрээ дагалдах гэрээ байгуулахаар ингээд зааж байгаа нь бол холбогдох хууль тогтоомжуудтай бас нийцэхгүй байна гэж үзэж байгаа. Ийм учраас энэ Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд оруулж байгаа энэ өөрчлөлтийг хууль санаачлагчид нь мөн буцаах нь зүйтэй гэж бид бас үзэж байгаа юм аа.

Ингээд завсарлага авсан 3 асуудлаар бүлгийн байр суурийг илэрхийлж байна. Улсын Их Хурлын даргаас Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг бас бид бүлгээрээ

үргэлжлүүлэн хэлэлцэх ийм шаардлага байна. Тийм учраас нэг хоногийн завсарлага өгөхийг хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Тэгэхээр Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 12.1 дэх заалтыг үндэслээд 12.1 биш байна. Энэ завсарлага авах зохицуулалттай холбоотой. Их Хурлын тухай хуулийн 12.1 дээр энэ хуульд өөрөөр заагаагүй бол нам эвслийн бүлэг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30.1.5-д заасны дагуу завсарлага авах эрхтэй. Завсарлага авах хугацаа ажлын 5-аас илүүгүй өдөр байх бөгөөд шаардлагатай бол нам эвслийн бүлгийн хүсэлтээр хуралдаан даргалагч завсарлагын хугацааг нэг удаа ажлын 3-аас илүүгүй өдрөөр сунгаж болно гэж ингэж заасан байна.

Тэгэхээр 1 хоногийн завсарлагын хугацаа буюу мягмар гаргийн 10 цагт бас Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы хуралдаан зарлагдсан байгаа. Хэлэлцэх асуудлууд бас товлогдсон. Хэрвээ завсарлагын хугацаа бас ингээд дуусвал маргаашийн чуулганы нэгдсэн хуралдаанаар бүх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцээд явах боломжтой гэж ингэж бодож байна аа. Ингээд нэг өдрийн завсарлагын хугацааг сунгалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА